



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 19 өдөр

Дугаар A/555

Булган сум

### Г Дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, Амьтны тухай хуулийн 29<sup>1</sup> дүгээр зүйл, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх заалт, 8.1 дүгээр зүйлийн 1.23 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барих тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдаа зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар байгуулсугай.

2. Тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барих зөвшөөрөл олгох дуудлага худалдааг зохион байгуулах удирдамжийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3. Тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барих тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдааг хууль, журманд нийцүүлэн зохион байгуулж дуудлага худалдааны тайлан мэдээг тайлагнахыг ажлын хэсгийн дарга (Г.Давааням)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Алтаншагай)-д даалгасугай.



6323010584

Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын  
19-ний өдрийн захирамжийн 1 дүгээр хавсралт

А/555

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн эрхзүйн сургалт сурталчилгаа хариуцсан ахлах мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхайн бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Байгаль орчин, аялал жууллалын газрын дарга

Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Биологийн төрөл зүйл, сургалт сурталчилгаа, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын  
19-ний өдрийн дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

**ТУСГАЙ ЗОРИУЛАЛТААР АМЬТАН АГНАХ, БАРИХ ДУУДЛАГА  
ХУДАЛДААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6, Амьтны тухай хуулийн 29<sup>1</sup> дүгээр зүйлд заасны дагуу дэнчин төлж бүртгүүлсэн аж ахуй нэгж, байгууллага түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд халиун буга, тул загасыг тусгай зориулалтаар агнуулах зөвшөөрлийн дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулах ажлын хэсгийн үйл ажиллагааг энэхүү удирдамжаар зохицуулна.

1.2. Тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барих зөвшөөрлийн дуудлага худалдаа /цаашид “дуудлага худалдаа” гэх/-г явуулах удирдамж, ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар дуудлага худалдаа эхлэхээс өмнө батална.

1.3. Дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Орон нутгийн өмчийн газар, аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэс, БОАЖГазар, Байгаль орчны чиглэлийн ТББ-аас нэг төлөөлөл оролцуулж болно. /цаашид “ажлын хэсэг” гэх/. Дуудлага худалдаагаар тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар голлох үүрэгтэй оролцож, удирдан зохион байгуулна.

1.4. Засгийн газрын тогтоолд заасан тусгай зориулалтын агнуурын зөвшөөрлийн дуудлага худалдааны эхлэх босго үнийн хэмжээг дуудлага худалдааны анхны үнийн санал гэж тооцно.

**Хоёр. Дуудлага худалдаа зохион байгуулахад баримтлах зарчим**

2.1. Нээлттэй, ил тод байх;

2.2. Тэгш, шударга, оролцоог хангасан байх;

2.3. Холбогдох хууль тогтоомжийн заалтуудыг чанд мөрдөх;

**Гурав. Дуудлага худалдаа явуулах дараалал**

3.1. Дуудлага худалдааны бэлтгэл ажлыг хангах;

3.2. Дуудлага худалдааны товыг зарлан мэдээлэх;

3.3. Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх, баталгаажуулах;

3.4. Дуудлага худалдааг эхлүүлэх, дуусгавар болгох;

3.5. Дуудлага худалдааны ялагчийг зарлах, баталгаажуулах;

3.6. Ан агнах зөвшөөрлийн бичиг олгох;

**Дөрөв. Дуудлага худалдааны бэлтгэл ажил**

4.1. Хуульд заасан шаардлагад нийцсэн, төрийн байгууллагуудад ашиглагдаж туршигдсан, программ хангамж ашиглах туршилт хийж бэлэн болгоно. Аудио, видео бичлэг хийж хадгалах баталгаажуулах, зохион байгуулагчид болон бүх оролцогчид харилцан хяналт тавих боломж бүхий zoom буюу түүнтэй төстэй программ ашиглана.

## **Тав. Дуудлага худалдааны зарыг нийтэд мэдээлэх:**

5.1.Дуудлага худалдааны зар (цаашид “зар” гэх)-ыг цахимаар дараах байдлаар нийтэд мэдээлнэ.

5.1.1.Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр;

5.1.2.Аймгийн нутгийн захиргааны байгууллагын цахим хуудсаар;

5.2.Дуудлага худалдааны зард:

- Дуудлага худалдааг явуулах программ хангамж
- Дуудлага худалдааны тов, эхлэх өдөр, цаг, минут
- Агуурын амьтны зүйлийн нэр, тоо толгой
- Босго үнэ, дэнчингийн хэмжээ
- Дэнчин төлөх дансны дугаар
- Дэнчин төлөх сүүлийн хугацаа
- Дуудлага худалдаанд хэлэх үнийн дээд, доод хязгаар
- Оролцогчдыг бүртгэж эхлэх болон бүртгэлийг хаах цаг
- Дуудлага худалдаа зохион байгуулах цахим хуудасны мэдээлэл /дуудлага худалдаа явуулах тусгай программ хангамж, харилцах утасны дугаар/ бусад шаардлагатай мэдээллүүдийг багтаана.

## **Зургаа. Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх**

6.1.Дуудлага худалдаанд оролцох хүсэлтийг хүлээн авах хугацааг дуудлага худалдааны зар зарлагдсан цагаас эхлэн, дуудлага худалдаа эхлэхээс **24** цагийн өмнө хаана.

6.2.Дэнчин төлсөн хугацаа, дэнчингийн мөнгөн дүн, оролцох төлөөлөл болон итгэмжлэгдсэн төлөөлөгчийг батлах баримт бичиг зэргийг хянан үзэж, шаардлага хангаагүй бичиг баримтыг бүрдүүлэхийг дуудлага худалдаа эхлэхээс **12** цагийн өмнө хүсэлт гаргагчид мэдэгдэж баримт бичгийн болон бусад зөрчилөө арилгах боломж олгоно.

6.3.Оролцогчдын ирүүлсэн хүсэлт, шаардлагатай баримт бичгийг хянан баталгаажуулж, шаардлага хангасан оролцогчдод хүсэлтийг хүлээн авснаас хойш **12** цагийн дотор багтааж дуудлага худалдаанд оролцох эрхийг баталгаажуулсан мэдэгдлийг цахим дуудлага худалдаа явуулах тусгай программ хангамжид нэвтрэх нэр, нууц үг, бусад мэдээллийн хамт хүргүүлнэ.

6.4.Дуудлага худалдаанд оролцогчдын бүртгэл, мэдээллийг дуудлага худалдааг нээх хүртэлх хугацаанд бусдад мэдээлэхийг хориглоно.

## **Долоо. Дуудлага худалдаа явуулах**

7.1.Аймгийн Засаг дарга дуудлага худалдаа явуулах ажлын хэсгийг байгуулж, дуудлага худалдааг ажлын хэсэг зохион байгуулна.

7.2.Дуудлага худалдаа явуулах ажлын хэсэг нь дарга, дуудлага худалдааны хөтлөгч (зарлагч), тэмдэглэл хөтлөгч гэсэн үүрэг бүхий энэ удирдамжийн 1.3-т заасан бүрэлдэхүүнтэй байна.

7.3.Дуудлага худалдааны явцад үүссэн маргааныг тухайн дуудлага худалдаа явуулах ажлын хэсэг хянан шийдвэрлэнэ.

7.4.Дуудлага худалдаа явуулах ажлын хэсгийн дарга дор дурдсан эрх, үүрэгтэй.

7.4.1.Дуудлага худалдаа явуулах ажлыг бүрэн хариуцах;

7.4.2.Дуудлага худалдаа явуулахад зөвлөх ажилтныг сонгон ажиллуулах;

7.4.3.Дуудлага худалдааны явцын тэмдэглэл, дуу, дүрсний бичлэгийг;

үнэн зөв, бүрэн хөтөлгөсөн эсэхийг хянаж батапгаажуупан, дуудлага худалдаанд оролцогчид болон зохион байгуулагч талын төлөөлөл тэмдэглэлд гарын үсгийг цахимаар зурах;

7.5.Дуудлага худалдааны хөтлөгч дор дурдсан эрх, үүрэгтэй:

7.5.1.Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэж, хувийн дугаар олгох;

7.5.2.Дуудлага худалдааг товлосон хугацаанд нь эхлүүлэх;

7.5.3.Үнэ хаялцуулах дэгийн дарааллын талаар болон өсгөн хэлэх үнийн хэмжээг зарлаж танилцуулах;

7.5.4.Дуудлага худалдааны явцын тэмдэглэлийг үнэн зөв, бүрэн хөтлүүлэх;

7.6.Дуудлага худалдааны тэмдэглэл хөтлөгч дор дурдсан эрх, үүрэгтэй:

7.6.1.Дуудлага худалдааны явцын тэмдэглэлийг үнэн зөв, бүрэн хөтлүүлэх;

7.6.2.Дуудлага худалдааны явцын тэмдэглэлд оролцогчдоор цахим гарын үсэг зуруулах;

7.6.3.Дуудлага худалдааг товлосон хугацаанд оролцогчдыг цахим хаягт оролцохыг утсаар холбогдож урих, оролцогч 2 дахь удаагаа урихад орж ирээгүй тохиолдолд түүнийг дуудлага худалдаанд оролцохос татгалзсанд тооцож, энэ тухай тэмдэглэлд тусгана.

7.6.4.Бүртгэлийн ажиллагаа дууссаны дараа дуудлага худалдаа явуулах ажлын хэсгийн дарга оролцогчдод тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа явуулах захирамж, түүнтэй адилтгах шийдвэрийг уншиж сонсгоно.

7.6.5.Дуудлага худалдаа явуулах оролцогчдын материалыг шалгасны дараа энэ удирдамжийн 7.5.1-д заасан дугаарыг хуваарилж олгоно.

7.6.6.Хөтлөгч оролцогчдод дуудлага худалдааны журам болон үнэ хаялцуулах дэг, анхааруулах бусад зүйлийг танилцуулна.

7.6.7.Хөтлөгч дуудлага худалдаанд явуулах цахим зохион байгуулалтыг танилцуулж, дуудлага худалдааны өсгөн хэлэх үнийн хэмжээг зарлан, дуудлага худалдаа эхлүүлнэ.

7.6.8.Өсгөн хэлэх үнийн хэмжээ Засгийн газрын тогтоолоор баталсан босго үнэ /Анхны дуудах үнэ 50,000 төгрөг байх бөгөөд дараагийн дуудах үнийн хэмжээ 50,000-200,000 төгрөгийн хэмжээнд тохируулан дуудна./

7.6.9.Оролцогч үнийн санал хэлэхэд хөтлөгч тухайн үнийн саналыг 3 удаа давтаж хэлнэ.

7.6.10.Бусад оролцогчид энэ удирдамжийн 7.7.6-д зааснаас дээш үнийн санал хэлээгүй тохиолдолд хөтлөгч “буулаа” гэж хэлээд “нэг”, “хоёр”, “тураав” гэж тоолсны дараа дохис өгч ялагчийг зарлаж, дуудлага худалдаа хаасныг мэдэгдэнэ.

7.6.11.Дуудлага худалдаанд оролцогчид дуудлага худалдааны тэмдэглэлд гарын үсэг зурна.

7.7.1.Цахим дуудлага худалдааг товлосон өдрийн цаг, минут, секундэд эхлүүлж, мөн өдрийн цаг, минут, секундэд зогсоно.

7.7.2.Энэ удирдамжийн 7.7.1-д заасан хугацаанд хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн оролцогчийг дуудлага худалдаа явуулах zoom программ хангамж ашиглан ялагчаар тодруулна.

7.7.3.Дуудлага худалдааны ялагч дуудлага худалдаа явагдсан өдрөөс хойш ажлын 1 хоногийн дотор дуудлага худалдааны төлбөрийг бүрэн төлж, Иргэний хуулийн 197 дугаар зүйлд заасны дагуу гэрээ байгуулах үүрэгтэй.

7.7.4.Цахим худалдааг заасан хугацаанд зогсоосноор оролцогчдоос ирүүлсэн үнийн санал тус бүрийн хугацааг цаг, минут, секундээр бүртгэн тэмдэглэлд тусгана.

7.7.5.Дуудлага худалдааны ялагчаас бусад оролцогчдын дэнчинг ажлын 3 өдөрт багтаан буцаан шилжүүлэх бөгөөд шилжүүлэх данс тодорхойгүй тохиолдолд цахим бүртгэл дэх утас, хаягаар оролцогчтой холбогдож шилжүүлнэ.

7.8.Дуудлага худалдаа явуулахтай холбогдсон энэ удирдамжаар зохицуулаагүй харилцааг Иргэний хуулийн 197 дугаар зүйл болон Амьтны тухай хуулийн 29<sup>1</sup> заасны дагуу зохицуулна.

#### **Найм. Дуудлага худалдаанд ялагчийг баталгаажуулах**

8.1.Дуудлага худалдаа бүрэн дууссанаас хойш ажлын 2 хоногт багтааж хуульд заасан хугацаанд төлбөрөө төлсөн баримт, ажлын хэсгийн тэмдэглэл зэргийг үндэслэн дуудлага худалдаанд ялагчийг аймгийн Засаг даргын захирамжаар баталгаажуулна.

8.2.Дуудлага худалдааны ялагч нь агнуурын бүс нутгийн менежмент хариуцагч бол Амьтны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.1 дэх заалтыг баримтлан, тусгай зөвшөөрлийг өөрийн менежмент хариуцдаг агнуурын бүс нутаг дээр бүртгүүлж, мөн хуулийн 25.1-д заасан гэрээг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газартай байгуулна.

8.3.Дуудлага худалдааны ялагч нь агнуурын бүс нутгийн менежмент хариуцагчаас өөр этгээд бол тухайн аймгийн аль нэг агнуурын бүс нутгийн менежмент хариуцагч болон аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газартай гурвалсан гэрээ байгуулна.

8.4.Тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах барих тусгай зөвшөөрлийг энэхүү удирдамжийн 8.2, 8.3-д заасан гэрээгээр агнуурын бүс нутагт олгоходоо агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөөнд заасан тухайн жилд агнах барих амьтны дээд тооноос хэтрүүлэхгүй байна. Мөн аймгийн Ерөнхий агнуур зохион байгуулалт, Менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй агнуурын бүсэд тусгай зөвшөөрөл олгож баталгаажуулахыг хориглоно.

8.5.Дуудлага худалдааны ялагчаас бусад оролцогчдын төлсөн дэнчинг ажлын 3 хоногт багтаан оролцогчдын дансанд буцаан шилжүүлнэ.

8.6.Хуульд зааснаас бусад үндэслэлээр дуудлага худалдаанд ялагчийг тодруулах, баталгаажуулах болон эс баталгаажуулах үйлдэл гаргахыг хориглоно.

**Ес.Тусгай зориулалтаар ан агнах, барих тусгай зөвшөөрлийн бичиг олгох**

9.1.Дуудлага худалдааны ялагчид дараах бичиг баримтын бүрдлийг үндэслэл болгон ан агнах тусгай зөвшөөрлийн бичиг олгоно. Үүнд:

- 9.1.1.Албан бичгээр ирүүлсэн хүсэлт,
- 9.1.2.Энэхүү удирдамжийн 8.2 буюу 8.3-д заасан гэрээний хуулбар,
- 9.1.3.Дуудлага худалдааны төлбөрийг бүрэн төлсөн баримт,
- 9.1.4.Агнуурын нөөц ашигласны төлбөрийн төлсөн баримт,
- 9.1.5.Агнуурын нөөц ашигласны хураамж төлсөн баримт,
- 9.1.6.Анчны паспортын хуулбар гэсэн бичиг баримтуудыг цахимаар хүлээн авч ан агнах зөвшөөрлийн хүсэлт ирүүлсэн өдрөөс хойш ажлын 3 хоногт багтаан олгоно.